0+680.000	966.415	966.486	0.071	3	—
0+700.000	966.313	966.546	0.232	3	—
0+720.000	966.047	966.606	0.559	3	20000.00
0+740.000	966.097	966.653	0.556	2	20000.00
0+760.000	966.423	966.680	0.258	1	20000.00
0+780.000	966.557	966.688	0.131	0	20000.00
0+800.000	966.326	966.675	0.349	-1	20000.00
0+820.000	966.312	966.650	0.338	-1	—
0+840.000	966.271	966.624	0.353	-1	—
0+860.000	966.299	966.599	0.300	-1	—
0+880.000	966.352	966.574	0.222	-1	—
0+900.000	966.317	966.549	0.232	-1	—
0+920.000	966.301	966.523	0.222	-1	—
0+940.000	966.292	966.498	0.206	-1	—
0+960.000	966.293	966.473	0.180	-1	—
0+980.000	966.255	966.447	0.192	-1	—
1+000.000	966.267	966.422	0.155	-1	—
1+020.000	966.206	966.390	0.184	-2	20000.00
1+040.000	966.132	966.338	0.206	-3	—
1+060.000	966.066	966.279	0.214	-3	—
1+080.000	965.976	966.220	0.244	-3	—
1+100.000	965.936	966.162	0.226	-3	—
1+120.000	965.862	966.103	0.240	-3	—
1+140.000	965.824	966.044	0.220	-3	—
1+160.000	965.758	965.985	0.227	-3	—
1+180.000	965.728	965.926	0.198	-3	—
1+200.000	965.667	965.867	0.199	-3	—

1+220.000	965.631	965.808	0.177	-3	—
1+240.000	965.547	965.749	0.202	-3	—
1+260.000	965.490	965.690	0.200	-3	—
1+280.000	965.395	965.631	0.236	-3	—
1+300.000	965.301	965.572	0.271	-3	—
1+320.000	965.242	965.513	0.272	-3	—
1+340.000	965.174	965.454	0.281	-3	—
1+360.000	965.150	965.395	0.245	-3	—
1+380.000	965.086	965.336	0.250	-3	—
1+400.000	965.018	965.284	0.265	-2	-30000.00
1+420.000	965.105	965.244	0.139	-2	—
1+440.000	965.071	965.211	0.140	-2	—
1+460.000	965.075	965.178	0.103	-2	—
1+480.000	964.968	965.145	0.178	-2	—
1+500.000	964.892	965.112	0.220	-2	—
1+520.000	964.885	965.079	0.194	-2	—
1+540.000	964.863	965.046	0.183	-2	—
1+560.000	964.782	965.013	0.231	-2	—
1+580.000	964.740	964.980	0.240	-2	—
1+600.000	964.759	964.947	0.188	-2	—
1+620.000	964.685	964.914	0.229	-2	—
1+640.000	964.636	964.881	0.245	-2	—
1+660.000	964.598	964.848	0.249	-2	—
1+680.000	964.520	964.815	0.294	-2	—
1+700.000	964.508	964.781	0.273	-2	—
1+720.000	964.524	964.748	0.225	-2	—
1+740.000	964.505	964.715	0.210	-2	—
1+760.000	964.487	964.682	0.195	-2	—
1+780.000	964.446	964.649	0.203	-2	—
1+800.000	964.413	964.616	0.203	-2	—
1+820.000	964.350	964.583	0.233	-2	—
1+840.000	964.315	964.550	0.235	-2	—
1+860.000	964.334	964.517	0.183	-2	—
1+880.000	964.292	964.484	0.192	-2	—
1+900.000	964.202	964.451	0.249	-2	—
1+920.000	964.254	964.418	0.164	-2	—
1+940.000	964.169	964.385	0.215	-2	—
1+960.000	964.124	964.352	0.227	-2	—
1+980.000	964.115	964.319	0.204	-2	—
2+000.000	964.077	964.286	0.209	-2	—
2+020.000	964.039	964.252	0.214	-2	—
2+040.000	963.955	964.219	0.265	-2	—
2+060.000	963.906	964.186	0.280	-2	—

2+080.000	963.891	964.153	0.262	-2	—
2+100.000	963.847	964.120	0.273	-2	—
2+120.000	963.839	964.087	0.249	-2	—
2+140.000	963.803	964.054	0.251	-2	—
2+160.000	963.770	964.020	0.250	-2	40000.00
2+180.000	963.703	963.977	0.274	-2	40000.00
2+200.000	963.706	963.924	0.218	-3	40000.00
2+220.000	963.629	963.861	0.233	-3	40000.00
2+240.000	963.554	963.789	0.235	-4	40000.00
2+260.000	963.417	963.707	0.290	-4	—
2+280.000	963.399	963.625	0.226	-4	—
2+300.000	963.308	963.542	0.234	-4	—
2+320.000	963.212	963.459	0.247	-4	—
2+340.000	963.167	963.377	0.210	-4	—
2+360.000	963.087	963.294	0.207	-4	—
2+380.000	963.010	963.212	0.202	-4	—
2+400.000	962.906	963.129	0.223	-4	—
2+420.000	962.823	963.047	0.224	-4	—
2+440.000	962.717	962.964	0.247	-4	—
2+460.000	962.642	962.881	0.240	-4	—
2+480.000	962.598	962.799	0.201	-4	—
2+500.000	962.541	962.714	0.173	-4	50000.00
2+520.000	962.438	962.623	0.184	-5	—
2+540.000	962.317	962.529	0.212	-5	—
2+560.000	962.207	962.435	0.228	-5	—
2+580.000	962.089	962.341	0.253	-5	—
2+600.000	962.024	962.248	0.224	-5	—
2+620.000	961.923	962.154	0.231	-5	—
2+640.000	961.863	962.060	0.197	-5	—
2+660.000	961.712	961.966	0.254	-5	—
2+680.000	961.684	961.873	0.189	-5	—
2+700.000	961.588	961.779	0.191	-5	—
2+720.000	961.476	961.685	0.210	-5	—
2+740.000	961.386	961.591	0.206	-5	—
2+760.000	961.349	961.498	0.148	-5	—
2+780.000	961.214	961.404	0.190	-5	—
2+800.000	961.183	961.310	0.128	-5	—
2+820.000	961.052	961.217	0.164	-5	—
2+840.000	960.910	961.123	0.213	-5	—
2+860.000	960.819	961.029	0.210	-5	—
2+880.000	960.750	960.935	0.185	-5	—
2+900.000	960.714	960.842	0.128	-5	—
2+920.000	960.610	960.748	0.138	-5	—

2+940.000	960.417	960.654	0.238	-5	—
2+960.000	960.370	960.560	0.190	-5	—
2+962.286	960.389	960.550	0.160	-5	—

5.7 Хөдөлгөөний аюулгүй байдал

Автотээврийн салбарын болон хөдөлгөөний аюулгүй байдлын хүрээн дэх эрхзүйн харилцаанд хамаарах, өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол улсын 10 гаруй хууль, тухайлбал "Монгол улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай", "Автозамын тухай", "Автотээврийн тухай", "Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татварын тухай", "Захиргааны хариуцлагын тухай", "Эрүүгийн хууль", "Иргэний хууль", "Цагдаагийн байгууллагын тухай" зэрэг хуулиуд мөн 2004 онд шинэчлэгдэн батлагдсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа"Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм", түүнчлэн МУ-ын Засгийн газар, яам, тамгын газруудаас батлан гаргасан, тухайлбал "Тээврийн хэрэгсэлийн тооллого, техникийн хяналтын үзлэг явуулах", "Автотээврийн хэрэгсэлээр ачаа, зорчигч тээвэрлэх", "Овор ихтэй, урт, хүнд ачааны тээвэрлэлт" MNS5345:2003 ерөнхий шаардлага, "Хүнд даацын автотээврийн хэрэгсэл" MNS 6278:2011, "Авто замын тэмдэг" MNS 4597 : 2014, "Авто замын тэмдэглэл."MNS 4759-2014, "Авто замын гэрлэн дохио" MNS 4980 : 2014, "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм"MNS 4596 : 2014, "Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүдMNS 4599-2003 зэрэг автозам, автотээврийн салбарын тогтолцооны 20 гаруй стандарт байна. Мөн Монгол улсын соёрхон баталсан буюу нэгдсэн "Замын хөдөлгөөний тухай Венийн конвенц", "Замын дохио, тэмдгийн тухай Венийн конвенц", "Олон улс хоорондын автозамаар ачаа тээвэрлэх гэрээний тухай Базелийн конвенц" НҮБ-аас гаргасан Тогтвортой хөгжлийн бодлогод манай улс нэгдсэн билээ.

Эрүүл мэнд буюу 3-р зорилтын 6-р заалтыг бид мөрдөж ажиллах ёстой. Өөрөөр хэлбэл 2-р 10 жилд /2021-2030/ ЗТО-ын тоог 2 дахин бууруулах үүрэг авсан байгаа. Өөрөөр хэлбэл тухайн гудамж замын ашиглалтын үеийн тооцоот хурдыг бариулах тал дээр зураг төслийн хувьд дараах арга хэмжээг авсан болно.

- Замын хэвтээ болон босоо тэмдэг тэмдэглэгээг стандарт, норм дүрмийн дагуу тавих.
- Шаардлагатай байршлуудад хурд сааруулагч тавих,
- Хэвтээ болон босоо төлөвлөлтөд үзэгдэх орчны хязгаарыг баримтлах.
- Замд нийлэх боломжийг бүрэн буюу хагас хязгаарлах
- Нэг төвшингийн уулзвар, огтлолцоог цөөлөх

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах замыг тоноглолын ажлууд хийгдэнэ.

- Замын тэмдэг
- Замын тэмдэглэгээ
- Хурд сааруулагч
- Төмөр хайс

Замын тэмдэг, тэмдэглэгээний хийц, бичиглэлийн хувьд

1.Авто замын тэмдэглэл.Техникийн ерөнхий шаардлага. MNS 4597:2014

2.Авто замын тэмдэглэл.Техникийн ерөнхий шаардлага. MNS 4597:2014
3.Автозамын тэмдэг, тэмдэглэл гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм. MNS 4596:2014 гэсэн Монголын стандартуудыг дагаж мөрдөнө.

Төслийн замын дагуу замын тэмдэг, тэмдэглэгээний тоо хэмжээ, байршлыг ажлын зурагт үзүүлсэн болно.

БҮЛЭГ-6 ЗАРДЛЫН ТООЦОО

6.1 Танилцуулга

Төлөвлөж буй автозамын барилгын ажлын төслийн зардлын тооцоог 2024 оны 02 сарын Монгол улсад мөрдөж буй зах зээлийн үнэ тарифт үндэслэн хийсэн. Арматур төмөр, цемент, битум гэх мэт материалын зах зээлийн үнийг одоогийн зах зээлийн ханшаар авсан бөгөөд тээвэрлэлтийн зардал орсон болно. Ажилчдын цалин хөлсний тухай Монгол улын хөдөлмөрийн хуулийг харгалзан үзсэний үндсэн дээр зах зээлийн ханшаар ажиллах хүчний зардлыг тооцсон. Төлбөр хийх зүйлсийн сонголтыг төслийн тооцоо, ажлын зураг, техникийн шаардлага зэрэгт үндэслэн хийсэн.

6.2 Хамрах хүрээ

Төслийн замын зардлын тооцоонд дараах ажлууд хийгдэнэ. Үүнд:

- Талбайн цэвэрлэгээ
- Замын суурь, хучилтын ажил
- Явган зам
- Газар шорооны ажил
- Ус зайлуулах энгийн байгууламж,
- Замын тэмдэг, тэмдэглэгээ, тоноглол

6.3 Нэгж үнэ

Ажлын төрөл зүйлийн нэгж үнийг тооцоход дараахи гол хүчин зүйлүүдийг харгалзан үзсэн. Үүнд:

(а) Барилгын материалын (шороо, агрегат, хайрга, элс) карьер, нөөц орд дахь үндсэн өртгийг тухайн хотын бүсээс авсан материалын үнийн жагсаалтын дагуу авсан.

(б) Зах зээлээс авах гол төрөл зүйлийн (битум, арматур, цемент гм.) өртгийг орон нутгийн үйлдвэрлэгчид болон ханган нийлүүлэгч агентлагуудаас асууж тодруулсан.

(в) Барилгын ажлын нийт төсөвт өртгийг Монгол Улсад мөрдөж байгаа дараахи стандартуудыг баримтлахын зэрэгцээ жижиг болон том ширхэглэлтэй асфальтбетоны зах зээлийн үнийн судалгаа авч төсөвт тусгасан болно.

RBC-ESTIMATOR Зам гүүрийн Барилга, Засварын ажлын төсвийн тооцооны программ хангамжийг ашиглан гаргалаа.

- БНбД 81-25-07 Авто замын барилгын төсвийн жишиг норм
- БНбД 83-17-07 Авто замын барилгын ажлын үйлдвэрлэлийн жишиг норм
- БНбД 83-4В-07 Төмөрбетон гүүр, хоолойн барилгын ажлын үйлдвэрлэлийн жишиг норм

• БНбД 81-28-07 Төмөрбетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм Зардлын тооцоонд ашигласан нэгж үнэ нь гүйцэтгэж дууссан ажлын төрөл зүйлүүдэд хамаарах бөгөөд бүх талаар бүрэн гэж тооцно. Үүнд барилгын үйлдвэр завод, тоногтөхөөрөмж, багаж хэрэгсэл, материал, ажиллах хүч, бүх түр ажлууд, угсралт, засвар арчлалт, туслах чанарын болон бэлтгэл ажлууд багтана. Гүйцэтгэгчийн удирдлагын зардал, ашиг, ерөнхий эрсдлүүд, даатгалын төлбөр зэргийг ашигласан нэгж үнэнд оруулан тооцов. Төслийн замын ойролцоох барилгын материалын нөөцийн олдоц, хүрэх зай зэргийг нэгж үнийг бодож гаргахад харгалзан үзсэн.

БҮЛЭГ-7. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Энэхүү бүлэгт барилгын ажлын үед Хөдөлмөрийн Аюулгүй Байдал болон Эрүүл Ахуйн шаардлагыг хэрхэн хангах тухай тусгасан бөгөөд ХАБЭА –н шаардлагууд нь тухайн байгууллага компани, орчин нөхцлөөс хамаарч зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй болно.

Тухайн ажлын явцад Аюулгүй байдал Хөдөлмөр хамгааллын Инженер болон Ажилтан зайлшгүй байх шаардлагатай бөгөөд тусгайлан бэлтгэгдсэн, сургалтанд хамрагдсан, ажлын туршлага дадлагатай байх шаардлагатай.

Хөдөлмөр хамгааллын инженер <u>өдөр бүр ажил эхлэх бүрт</u> ажилтан, албан хаагчид, машинист механизмын ажилчдад ХАБЭА-н зааварчилгаа өгөх ёстой.

Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа

Тус компани нь хөдөлмөрийн стандартыг баримтлан ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөлийг, ажлын байрны нөхцөл, аюулгүй байдлыг стандартын шаардлагад нийцүүлсэн ба хөдөлмөрийн норм, стандарт өөрчлөгдсөн тохиолдолд түүнийг баримтлана.

Ажилтанд хөөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар мэдлэг олгох сургалт явуулах, аюулгүй ажиллагааны зааварчилга өгч, биелэлтэд хяналт тавина.

Засвар, үйлчилгээ явуулах ажлын байрны агаарын температур, харьцангуй чийглэг, дуу шуугианы хэмжээ, үндсэн ба туслах байрны гэрэлтүүлэгийг нь стандартад заасан хэмжээнд байна.

Ажлын байранд байгалийн гэрэлтүүлэгийн коффициент 1,5 хувиас багагүй байна. Гэрэлтүүлэг нь ажлын байрны талбарт жигд тархсан, гялбалт үүсэхгүй байх шаардлагатай ба гэрэлтүүлэгчийн үүсгэврийг тогтмол хугацаанд цэвэрлэж байвал зохино.

Ажлын байранд тоос, химийн бодис тархахаас сэргийлэн, салхивчийн ерөнхий ба хэсгийн системийг төлөвлөх, ажлын үед агаар сэлгэх төхөөрөмжийг зориулалтын дагуу ажиллуулж байх, агаар сэлгэх төхөөрөмжийн ажиллагаанд тогтмол үзлэг хийж, эвдэрсэн тохиолдолд бүрэн засвар хийж цэвэрлэж байвал зохино

Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм заавартай, зохих журмын дагуу хөтлөгдсөн техникийн паспорттай ба хөдөлмөрийн хяналтын байгууллагаас ашиглах зөвшөөрлийн гэрчилгээтэй болно.

Цахилгаан тоног төхөөрөмж нь зураг төслийн дагуу угсрагдсан, цахилгааны ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангасан байна.

Ажиллагчдын ахуйн байр нь ариун цэвэр, эрүүл ахуйн норм, стандартыг хангасан байна.

Ажилтаны ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл нь тухайн ажил мэргэжлийн онцлогт тохирсон материалаар хийгдсэн хэв загвар нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангасан ба ажлын тусгай хувцасны чанарын үзүүлэлтийн жагсаалтыг баримтлан ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн жагсаалт, эдэлгээний хугацааг баталсан.

Ажилтныг ажилд шинээр ороход эмнэлэгийн үзлэг хийлгэж, эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэхийг тодорхойлуулсан байх ба тэднийг мэргэжлийн өвчин, архаг хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт зохих журмын дагуу хамруулна.

Хүнд, хүчир ажлыг механикжуулах, автоматжуулах, хөдөлмөрийг хөнгөвчлөх талаар арга хэмжээ авч, техник технологийн шинэчлэл хийх, хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ.

Ажлын байранд анхан шатны тусламж үзүүлэх аптектай байна.

Галын аюулгүй байдлыг хангах дотоод дүрэмтэй байна. Галын дохиолол, гал унтраах тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай байлган ажилтнуудаа уг тоног төхөөрөмжийг ашиглаж сургасан байх ба галын аюулаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Ажилчдад өгөх зааварчилгааны төрлүүд

Өдөр тутмын зааварчилгаа

Геодезийн бэлтгэл ажил хийх ажлын заавар

Авто зам, барилгын ажилд геодезийн хэмжилт, боловсруулалт хийх үеийн геодезийн инженер, техникч, туслах ажилчдын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Лабораторийн инженер, техникч, туслах ажилчдын хяналт, шинжилгээ хийх заавар

Лабораторийн инженер, техникч, туслах ажилчдын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Түр зам барих ажлын заавар, аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Карьер нээх, хөрс хуулах, төмөр бетон хоолой барих, далан барих, суурь барих, асфальт бетон хучилт барих, цемент бетон хучилт барих, авто замын хөвөө хийх, авто замын тоноглол тохижилтын ажил хийх ажлын зааврууд, аюулгүй ажиллагааны зааварчилгаанууд

Дизель цахилгаан станцын аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Гагнуурчин, цахилгаанчин, тоног төхөөрөмж машин механизмын завсарчны ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Үйлдвэрлэлийн багаж хэрэгслийн ажиллуулах аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны өдөр тутмын зааварчилгаа

Ажил эхлэхийн өмнө хөдөлмөр хамгааллын хувцсаа бүрэн өмсөж хамгаалах хэрэгсэлээ бүрэн бүтэн байдлыг нь шалга. Энэ өдөр ажил гүйцэтгэхэд ашиглах багаж, материал бусад шаардлагатай зүйлээ ойртуулж хэрэглэхгүй эд юмсыг ажил хийхэд саад болохооргүй болго.

Цахилгаан, тоног төхөөрөмжийн хаалт хамгаалалт, разеток, унтраалга болон бусад зүйл аюулгүй ажиллагааны шаардлага хангаж байгаа эсэхийг шалга.

Бусад ажилтнаа ажлаа аюулгүй тайван гүйцэтгэхэд саад болохгүй байх ба хөгжим тавих, утсаар ярих зэргээр зэргэлдээх ажилтныхаа анхаарлыг бүү сарниул

Гэнэтийн аюул учирсан үед ажилчид явахад зориулсан зам талбайг чөлөөтэй байлгах, шаардлагатай багаж, хэрэгсэл, төхөөрөмжийг ашиглахад бэлэн байлга.
Галын аюулгүй байдлыг чанд сахиж ил гал гаргах, зориулалтын бус газар тамхи татахыг хатуу хориглоно.
Машин механизмын дээр доор дотор засвар техникийн үйлчилгээ хийхдээ өндрөөс унах, машин механизм хооронд хавчуулагдах, хөл гар бие дээрээ хүнд төмөр багаж, хэрэгсэл унагааж бэртээх, эргэлдэх хөдөлгөөнтэй багаж болох точиль, хөрөө рам, таслагч, сэнс болон бусад багаж төхөөрөмжид ороцолдох, хуруу гараа тасдах, автомашины дугуйнд дайрагдах, цахилгаанд цохиулах зэрэг эрсдэлтэй тул техникийн аюулгүйн дүрэм болон инженер механик нарын заавар зөвлөгөөг чанд сахин даган мөрдөж, өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалж маш анхаарал болгоомжтой ажилла.
Хийн баллон, дизель генератор, гагнуурын аппарат болон шатах тослох материал, тэсэрч дэлбэрэх бодис зэрэгтэй зөвшөөрөлгүй харьцахыг хориглоно.
Шинэ ажлын байранд шилжин ажиллаж байгаа бол хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны давтан зааварчилгаа, хэрэв аюул осолтой, онцгой болгоомжтой ажиллах ажил гүйцэтгэх гэж байгаа бол өдөр тутмын зааварчилгаа авахаа бүү март.
Мэргэжлийн эрх бүхий ажилтнаас бусад хүмүүс машин, цахилгаан хэрэгсэл, агааржуулалт, гэрэлтүүлгийн болон гал унтраах хэрэгсэлийг оролдох, засварлах, тохируулгыг өөрчлөх, хаалт хамгаалалт, тэдгээрийн хаяг бичээсийг авахыг тус тус хориглоно.
Талбай дээр автомашины хөдөлгөөнөөс болгоомжил.Автомашиныг ухрах хөдөлгөөн хийж байх үед ард нь зогсохыг хориглоно.
Чулуу үсрэхээс болгоомжилж заавал каскан малгайгаа өмс.
Харанхуй болон үзэгдэх орчин хязгаарлагдсан үед ажиллах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд гар чийдэн болон гэрэл ойлгогч хувцастай заавал ажилла.

Тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Жолооч нар нь сүүлийн үеийн Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийг мөрдлөг болгоно. Жолооч нь ажилд гарахын өмнө хөдөлгүүрийн масло, тосол тормосны шингэнээ шалгаж хөдөлгүүрийг асаах ба бүх гэрэл дохио, рулийн механизм, тормосийг ажиллагаатай эсэхийг шалгасны дараа л ажилд гарна.
Хөдөлгөөнд оролцохдоо суудлын бүсээ зүүж дуут дохио болон гэрэл шилжүүлэн хөдөлнө. Хальтиргаа гулгаатай замд, уулын уруу өгсүүр газар холын гэрэл шилжүүлэн хурдыг зөв тохируулан анхаарал болгоомжтой явах.
Ажиллаж байх үедээ дугуйн даралт ба гайкнуудыг байнга шалгаж байх.
Дугуй авахдаа дамократны хажуугаар урд хойд тэнхлэгт ивээс тулгуур хийхээс гадна дугуйг угсрах, хийлэхдээ нуух үсрэхээс болгоомжилж анхааралтай байх ба хамгаалалт хийх. Самосвалын кузов өргөсөн тохиолдолд засвар үйлчилгээ хийхдээ кузов буухаас хамгаалж зориулалтын тулгуур хийнэ.
Гагнуур хийх үед малгай, нүдний шил зэрэг хамгаалалтын хэрэгслэлийг заавал хэрэглэж занших ба тэжээлийн клемыг салгаж байх.
Тамхины иш асаагуур зэргийг тэсэрч дэлбэрэх бодис, дизель түлшнээс хол байлгаж гал алдахаас сэргийлэх. Жолооч нь тогтоогдсон маршрутаар явах бөгөөд эзэмшиж байгаа техникээ удирдах ажилтаны зөвшөөрөлгүйгээр дур мэдэн хувийн болон өөр бусад ажил хийхийг хориглоно.

Жолоочийн кабинд тогтоогдсон хэмжээнээс илүү хүн, гадны хүн тээх, кузов дээр зориулалтын бус ачаа ачих, хүн суулган тээвэрлэхийг хориглоно.
Засвар үйлчилгээ хийхдээ зөвхөн тохирсон багаж түлхүүр хэрэглэх ба ажлын шаардлага хангахгүй эрсдэлтэй багаж түлхүүр хэрэглэхийг хориглоно.
Авто машинд ямар нэг гэмтэл гарсан тохиолдолд механикт тэр дор нь мэдэгдэж байх
Жолооч нар тээвэр хийхдээ улсын болон орон нутгийн зөвшөөрөгдсөн замаар явж байх, шинээр зам гаргахыг хориглоно.
Хүйтний нөхцөлд хөдөлгүүрийн тос гэсгээх зориулалтаар задгай гал түлэхийг хориглоно.
Эцэж ядарсан, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үед машин жолоодохыг хориглоно. Хазгай налуу газар подьём өргөх, засвар үйлчилгээ хийхийг хориглоно.
Гүйцэж түрүүлэх үйлдлийг гүйцэтгэхдээ замын нөхцөл байдал, онцлогийг харгалзан туйлын анхаарал болгоомжтой замын хөдөлгөөний дүрэмд заагдсан хэм хэмжээг баримтлан гүйцэтгэнэ.
Ажлын талбарт тээврийн хэрэгслийн хурдны дээд хязгаар 50км\ц ба обьектын орчим 20 км\ц-аас хэтрүүлэхгүй байна.

а. Грейдерийн аюулгүй ажиллагаа

Ажлаа эхлэхийн өмнө техникийг асааж гэрэлтүүлэг, гэрэл, дохио, дуут дохио, жолоодлогын механизм, тормос зэргийн бүрэн бүтэн ажиллаж байгаа эсэхийг шалган гарсан гэмтлийг ИТА-д мэдэгдэж арилгуулна.
Грейдерийг ажиллуулж байхдаа заавал суудлын даруулгыг хэрэглэнэ. Хутга булагдсан, саад бартааг цохиж болзошгүй.
Ажилд гарахдаа хутгыг их биетэй 30 градусын өнцөг үүсгэн эргүүлж дээш татсан байна.
Түр буюу удаан зогсох, кабинаас буух зэрэг тохиолдолд зам чөлөөлж зогсох ба заавал гар тормос атсан байна.
Гэнэтийн эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд замын хөдөлгөөний дүрэмд заасны дагуу зам чөлөөлж зогсох ба боломжгүй тохиолдолд ослын зогсолтын тэмдэг тавьж нэн даруй ИТА-д мэдэгдэнэ.
Автогрейдер ба грейдерийг мод, хожуул, том, хад чулуутай газар ажиллуулахыг хориглох ба эргэлтийн үед хурд хамгийн бага байна.
Техникийн засвар үйлчилгээг хазгай налуу, уруу газар хийхийг хориглоно.

б. Кран, Индүү оператор нарт

Ажилд гарахын өмнө бүх эд анги агрегатуудын ажиллагаанд ямар нэг өөрчлөлттэй эсэхийг шалга. Өргөх ачаа нь краны даацнаас хэтрэхгүй байх, ажиллуулж байгаа үед анхаарлаа сарниулахгүй байх ба эргэх үедээ орчин тойрноо сайн ажиглаж дуут дохио өгч байх.
Гидрийн шингэний хэмийг байнга үзэж байх. Мөн троссыг мушгихгүй байлгах
Салхины хурд 10м\с-ээс илүү бол кранаар ажил хийхийг хориглоно.
Краныг зөвхөн дохиочны гарын дохиогоор ажиллуулна.
Кранаар ачааг хөндлөн чирэх, татаж зөөж болохгүй ба краныг тэгш гадаргуутай хатуу газар байрлуулж домкратыг заавал сунгаж түгжсэний дараа ажиллуулна.
Краны товчлуурыг зааврын дагуу зөв хэрэглэнэ.
Замын сул далан нурахаас болгоомжил. Шат гишгүүрээс хальтрах, явж байхад бууж суухыг хориглоно.

Ухрах хөдөлгөөн хийхдээ дохио байнга өгөх, тавцан дээр хүн суулгахыг хориглоно.
Самосвал, автогрейдерийн ухрах хөдөлгөөнөөс болгоомжил
Шатахуун авах ба, засвар үйлчилгээ хийдээ хөдөлгүүрийг заавал унтрааж тормос татсан байна.
Машин механизмын дээр доор дотор засвар техникийн үйлчилгээ хийхдээ өндрөөс унах, машин механизм дотор хавчуулагдах, хөл гар бие дээрээ хүнд төмөр багаж хэрэгсэл унагааж бэртээх, сэнс болон багаж төхөөрөмжид ороцолдох, автомашины дугуйнд дайрагдах, цахилгаанд цохиулах зэрэг эрсдэлтэй тул техникийн аюулгүйн дүрэм болон инженер механик нарын заавар зөвлөгөөг чанд сахин даган мөрдөж, өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалж маш анхаарал болгоомжтой ажилла.

БҮЛЭГ-8. АВТО ЗАМЫН АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Уулзвар огтлолцол гарц орцны талбайг нийт ажлын тоо хэмжээнд нэгтгэж оруулсан болно					
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
№	Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	25-01-01	Гэр барих	1гэр	3	
2	25-01-02	Бие засах газар байгуулах (3.0х2.5х2.0м)	1ш	2	
3	25-01-03	Ажилтнуудын зөөврийн сууц байрлуулах	1ш	3	
4		Дугуйтай зөөврйин сууц байрлуулах	1ш	3	
5		Гал тогооны зөөврийн байр байрлуулах	1ш	1	
6		Усны нөөцийн сав байрлуулах	1ш	2	
7	25-01-08	Контейнер байрлуулах (агуулахын зориулалттай, 40 тн)	1ш	1	
8		Шатахууны агуулах сав байрлуулах (50тн)	1ш	1	
9		Оффисын зөөврийн байр байрлуулах	1ш	1	
10		Лабораторийн зөөврийн байр байрлуулах	1ш	1	
11	25-01-16	Талбайн ариун цэврийн арга хэмжээ зохион байгуулах	1өдөр	1	
ЗАМЫН ЧИГ СЭРГЭЭХ					
№	Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	25-02-02	Замын чиг сэргээх (GPS)	1км	3.54	
ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ					
№	Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1		Хуучин бетон, хашлага зайлуулах	1у/м	1646	Одоо байгаа бетон зайлуулах
2	25-15-03	Одоо байгаа хуучин дохионы шонг шилжүүлэх	1ш	6	Одоо байгаа
3		Төмөр хайс шинээр хийх	1у/м	1700	Тойрог уулзвар дээр
4		Төмөр хайс шилжүүлэх	1у/м	1643	Одоо байгаа
5		Самбар шилжүүлэх	1ш	1	Одоо байгаа
6		Асфальтбетон хучилт хуулаж зайлуулах	1м2	965.282	Замын эргэлт хангайхгүй байгаа хэсэг дээр
7		Ургамлын үе бүхий хөрсийг хуулах, зөөж зайлуулах	1м3	15504.034	Өргөслөлт хийж буй хэсэг дээр
ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ					

Дорноговь аймгийн Замын-үүд сумын хүнд даацын авто замын уулзвараас төлбөр авах цэг хүртэлх 3.54км авто замыг өргөтгөн шинэчлэх нарийвчилсан зураг төслийн ажлын тайлбар бичиг

№	Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	25-04-04	Далангийн ул хөрс тэгшлэх, нягтруулах	1м2	72895.51	уулзвар, гарц хамт
2	25-07-12	Тохиромжгүй материал ухаж ачиж, зайлуулах (экскаватороор)	1м3	23125.36	Өөрийн шуудууны тоо хэмжээ багтсан болно.
3		Шороон ордоос зөөврөөр далан байгуулах	1м3	13282.10	
4		Түр зам байгуулах	1км	30.00	Карерь 25км зай болон түр зам хийх зайгаа бодсон
СУУРИЙН АЖИЛ					
№	Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
		Асфальтбетон тэгшилгээ үе хийх	1м2	2421.808	Тойрог уулзвар дээр
		Харлуулсан дайрган суурь h=8см	1м3	5843.6235	Зогсоолын тоо хэмжээ ороогүй болно.
		Цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь h=20см	1м3	8827.0666	Өргөслөлт болон зогсоол хэсэг дээр
		Хуучин хучилтыг дахин боловсруулж цементээр бэхжүүлсэн суурь үе h=20см	1м3	5684.1926	Одоо байгаа авто зам дээр
1	25-07-08	Суурийн доод үе h=30см	1м3	13872.75	Өргөслөлт болон зогсоол хэсэг дээр
АВТО ЗАМЫН ХАШЛАГАНЫ АЖИЛ					
№	Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	25-09-02	Замын хашлага байрлуулах (1.0 x 0.3 x 0.18 м)	1у/м	547	Гарц дээр
ХУЧИЛТЫН АЖИЛ					
№	Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	25-10-05	Дунд ширхэглэлтэй асфальтбетон хучилт h=5см	1м3	3656.58	уулзвар гарц, өргөслөлт хамт
2	25-10-01	Шингэн цацлага хийх (Prime coat)	1м2	73156.51	Хурд сааруулагч тоо хэмжээ орсон
		Шингэн түрхлэг хийх	1м2	72895.51	
2	25-10-01	Цементбетон хучилт h=20см	1м3	1410.69	Зогсоол дээрх
ХАЙРГАН ХӨВӨӨ БАЙГУУЛАХ					
№	Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	25-11-01	Хайрган хөвөө механизмаар байгуулах (Хучлага хийсний дараах асгамал хөвөө)	1м3	6567.59	
ЗҮЛЭГЖҮҮЛЭХ					
№	Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
3	25-16-03	Зүлэгжүүлэх	1м2	2642.079	
ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ АЖИЛ БА ЗАМЫН ТОНОГЛОЛ					
№	Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
		Замын километрийн тэмдэг суурьлуулах	1ш	6	

		Замын тэмдэгний босоо шон	1ш	13	Тоо хэмжээг өөр ажиллаар орлуулах
		Мэдээллийн самбар	1ш	1	
1	25-15-01	Замын тэмдэг суурилуулах	1ш	173	
2	25-14-03	Замын тэмдэглэлийг зориулалтын машинаар хийх /тэнхлэгийн уулзвар гарц дээрх эгнээний тэмдэглэл/	1у/м	20312.59	0.15м өргөнтэй урт/м илэрхийлэв.
3	25-14-03	Замын тэмдэглэлийг зориулалтын машинаар хийх /бусад тэмдэглэл/	1м2	2608.46	
4		Дохионы шон суулгах	1ш	4.00	Ус зайлуулах хоолойтой хэсэгт байрлуулах
ХУРД СААРУУЛАГЧ					
№	Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	25-22-07	Хурд сааруулагч байгуулах (Асфальтбетон хольцоор)	1м3	19.20	Хучилтын ажлын тоо хэмжээнд ороогүй болно.
2	25-14-03	Хурд сааруулагчийн тэмдэглэл хийх	1м2	190.20	
УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ					
Хос ф500 ган хоолойн тоо хэмжээ					
1		Хоолойн суурийн ухмал	1м3	119.25	
2		Хоолойн ул суурь нягтруулах h=15см	1м2	79.50	
3		Элс хайрган суурь байгуулах h=10см	1м3	3.71	
4		Бетон шал байгуулах B20 h=10см	1м3	3.71	
5		Бетон хамгаалалт хийх B20	1м3	12.95	Ган хоолойг хамгаалсан бетон
6		Ган хоолой байрлуулах	1у/м	53.00	
7		Хоолойн далбаа, толгойн хэсэглэл цутгах B25	1м3	4.20	
8		Хоолой болон далбаанд орох D13 арматур	тн	0.14	
9		Хоолой болон далбаанд орох D8 арматур	тн	0.01	
10		Түрхмэл ус тусгаарлагч хийх	1м2	82.15	Ган хоолойн гадар болон бетон хамгаалалтын гадар
11		Орох гарах хэсгийн толгойн чулуун бэхэлгээ хийх B15 h=20см	1м3	1.47	
12		Орох гарах хэсгийн бэхэлгээ B20 h=20см	1м3	1.80	
13		Орох гарах хэсгийн чулуун бэхэлгээ B15 h=20см	1м3	6.00	
14		Буцаан дүүргэлт	1м3	119.25	Ухмалын тоо хэмжээтэй ижил байна.
15		Урсгалын хэвийг засварлах	1м3	50.00	Ус орох гарах хэсэгт гадаргыг засаж ус чөлөөтэй өнгөрөх боломжтой болгоно.

Дорноговь аймгийн Замын-үүд сумын хүнд даацын авто замын уулзвараас төлбөр авах цэг хүртэлх 3.54км авто замыг өргөтгөн шинэчлэх нарийвчилсан зураг төслийн ажлын тайлбар бичиг

ЛАБОРАТОРИЙН ТУРШИЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ					
№	Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	
1	25-03-01	Хөрсний шинжилгээ	1удаа/500м3	67	
2	25-03-03	Элсний шинжилгээ	1удаа/500м3	28	
3		Орц тогтоох шинжилгээ	1удаа/500м3	67	
4	25-03-04	Чулууны шинжилгээ	1удаа/500м3	20	
ҮЙЛДВЭР, ЗАВОДЫГ АЧИЖ БУУЛГАХ, УГСРАХ, ХУРААХ АЖИЛ					
№	Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	
	25-23-01	Асфальтбетон хольцын үйлдвэр автомашинд ачиж буулгах, угсрах, хураах ажил	1иж бүрдэл	1	
2	25-23-04	Чулуу бутлан ангилах үйлдвэр авто машинд ачиж буулгах, угсрах, хураах ажил	1иж бүрдэл	1	
3	25-23-03	Цементээр бэхжүүлсэн суурийн материалыг холих үйлдвэр автомашинд ачиж буулгах, угсрах, хураах ажил	1иж бүрдэл	1	
ОБЪЕКТИЙГ АШИГЛАЛТАНД ОРУУЛАХ					
№	Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	25-20-02	Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах	1км	3.54	
2	25-19-02	Зам ашиглалтад өгөх үеийн хог цэвэрлэх	1км	3.54	

9. ХАВСРАЛТ

1. Ажлын даалгавар

2. Төлбөр хураах цэгийн барилганы ажлын даалгавар

БАТЛАВ
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
С.БАТБОЛД

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ХҮНД ДААЦЫН АВТО ЗАМЫН УУЛЗВАРААС ТӨЛБӨР АВАХ ЦЭГ ХҮРТЭЛХ 2.6 КМ АВТО ЗАМЫГ 4 ЭГНЭЭ БОЛГОН ӨРГӨТГӨН ШИНЭЧЛЭХ ТӨСЛИЙН ЗУРАГ ТӨСӨЛ (ДОРНОГОВЬ АЙМАГ, ЗАМЫН-ҮҮД СУМ) БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 8 сарын 01-ны өдөр № 31 Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн А/139, 2024 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн А/157 дугаар тушаал
2.	Байршил	Дорноговь аймаг, Замын-Үүд сумын нутаг дэвсгэр
3.	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Улсын төсөв
4.	Замын техникийн ангилал, замын зэрэг	1В-ОЗГЗ-ЗХН-4-100 (Төв замын сүлжээн дэх олон зурваст гол зам, зорчих хэсэг нь зааглагдсан, хөдөлгөөний 4 зурвастай байна.
5.	Замын эхлэлийн цэг	Замын-Үүд сумын хүнд даацын авто замын уулзвараас эхэлнэ. (Захиалагчтай зөвшилцөнө)
6.	Замын төгсгөлийн цэг	Замын-Үүдийн төлбөр авах цэг. (Захиалагчтай зөвшилцөнө)
7.	Замын хучилтын хийц	Зургийн ерөнхий инженерийн техникийн шийдэл, тооцоогоор сонгох
8.	Төлөвлөлтийн норм	• "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016 • "Хот суурины гудамж зам төлөвлөлт" БНбД 32-01-04 • "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" АЗУАГН 2.01.01-2004 • "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" БНбД 22.01.01*/2006 • "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил" БНбД 3.01.03-88 • "Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" MNS4597:2014 • "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" MNS4596:2014 • "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль /БД31-101-04/ барилгын дүрэм

- "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056:2009
- Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598: 2020
- Бусад шаардлагатай Монгол улсын холбогдох ЗЗБНбД, БНбД болон стандартуудыг хатуу баримтлан, тэдгээрт бүрэн нийцүүлэн гүйцэтгэнэ.

10. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа

Нэг үе шаттай, 2024 оны 3 дугаар улиралд багтаан гүйцэтгэнэ.

11. Зураг төслийн иж бүрдэл

- "Геодези зураг зүйн тухай" хуулийн 6.1.3 дугаар заалт, "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил" БНбД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу байр зүйн хэмжилтийн ажлын тайлан;
- Буурь хөрс болон зам барилгын ажилд хэрэглэх түгээмэл тархацтай (чулуу, далан, суурийн хайрга, хөрс гэх мэт) материалын тойм судалгаа болон буурь хөрс, замын далангийн материалын судалгааг хамруулсан инженер-геологи, геотехникийн хайгуул судалгааны ажлын тайлан;
- Замын нийт уртад техник ашиглалтын түвшингийн судалгаа, далан, сууринд ашигласан материалын судалгааны дүн, замын эвдрэлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт;
- Одоо байгаа хиймэл байгууламжийн хийц, ашиглалтын байдлын судалгаа дүгнэлт;
- Дараах хэсгүүдийг нэгтгэсэн Авто замын ажлын иж бүрэн зураг төсөл:
  - Тухайн авто замыг барьж бүрэн дуусгахад шаардлагатай (Нийтийн тээвэрт зориулсан түр зам, газрын өнгөн хөрс хуулах, ус өнгөрүүлэх хоолой ба ус зайлуулах бусад байгууламж, ул хөрс солих, шороон далан, ухмал, далангийн дээд үе, тусгай үеүд, суурийн дэвсгэр үе, замын суурь ба хучлага, замын тоноглол, бетон барьер, хөдөлгөөн зохицуулалтын ба аюулгүй байдлын хэрэгслүүд, тэмдэг ба тэмдэглэл, зогсоол ба амрах талбай, зам барилгын зурваст орсон шилэн кабелийг хамгаалах, цас хунгарлалтыг багасгах хэрэгсэл зэрэг) бүх төрлийн ажлын (гэхдээ эдгээрээр зөвхөн хязгаарлагдахгүй) нарийвчилсан зураг,

- Авто замын зураг төсөлд тусгагдсан бүх ажлын техникийн шаардлага (ТШ),
- Авто замын зураг төсөлд тусгагдсан бүх төрлийн ажлын болон барилгын нийт ажлын тоо хэмжээний жагсаалт (АТХЖ),
- Авто замын өртгийн инженерийн нарийвчилсан тооцоо (ИНТ),
- Инженерийн дэлгэрэнгүй тайлан (ИДТ),
- Байр зүйн судалгааны болон геодезийн хэмжилтийн ажлын дэлгэрэнгүй тайлан,
- Геоморфолог, гидрогеолог, геотехникийн болон материалын олдоцын судалгааны дэлгэрэнгүй тайлан
- Гадаргуугийн усны ба цаг уурын судалгааны дэлгэрэнгүй тайлангаас бүрдэнэ.
- Авто замын зурваст орсон инженерийн байгууламж, цахилгаан, холбоо, дулаан, шилэн кабелийн шугам сүлжээний зураг төсөл, техникийн нөхцөлийг холбогдох байгууллагуудаас авах, авто замын трасст орсон иргэн, аж ахуй нэгжийн газар чөлөөлөх (газар, обьект), нүүлгэн шилжүүлэх ажлын судалгаа гаргах, ажлын тоо хэмжээ, зардал;
- Авто замын барилгын ажилтай холбоотой газар олгосон орон нутгийн засаг захиргааны захирамж болон бусад зөвшөөрөл, техникийн нөхцөлүүд;
- Том оврын тээврийн хэрэгслийн зогсоолын талбайн зураг төсөл;
- Байгаль орчны ерөнхий үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээ хийх.
- Авто замын хөндлөн огтлолын зураг төслийг 20 м тутамд хийх.

- Зураг төслийн иж бүрдэл тус бүрийг баталгаажуулсан Магадлалын ерөнхий дүгнэлт;
- Зураг төслийг Монгол, Англи хэл дээр боловсруулна.
- Зураг төслийг эх хувь 1ш, хуулбар 1ш /хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах/, тоон хэлбэрээр /*dwg, *kmz, *pdf/ хүлээлгэж өгнө. Тоон байдлаар бүх бичиглэлийн материалыг *.doc, *.xls өргөтгөлтэйгөөр, зураглалын материалыг *.dwg, *.shp өргөтгөлтэйгөөр баримт бичгийн бүрдлийг *.pdf өргөтгөлтэйгөөр CD болон DVD-ээр хүлээлгэн өгнө.

12. Зураг төслийн байгууллага

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан

	авах тухай" хуулийн дагуу шалгарсан хуулийн этгээд
13. Захиалагч байгууллага	Зам, тээврийн яам
14. Онцгой нөхцөл	• Замын-Үүдийн төлбөр авах цэгийг шинэчлэн барих зураг төслийг батлагдсан ажлын даалгаврын дагуу боловсруулах; • Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар"-аас геодезийн өндөржилтийн цэгийг авах бөгөөд замын трассын дагуу хатуу цэгийг тогтоож, стандартын дагуу бэхлэх, геодезийн ажлын тайланг тус газарт хүргүүлж, бүртгүүлсэн тухай албан бичгийг ИДТ-д хавсаргах; • Замын эхлэл, төгсгөлийн цэгийг Захиалагч байгууллагатай зөвшилцөнө. • Зайлшгүй шаардлагатай тохиолдолд олон улсад түгээмэл хэрэглэдэг зохих стандарт, нормыг захиалагчтай зөвшилцөж ашиглаж болно. • Уулзвар гарц, одоо байгаа замын огцом налуу болон эргэлт бүхий хэсгүүдийн хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах, цогц арга хэмжээг төлөвлөх; • Ухмал ба зам дээр цас хунгарлахаас сэргийлэх инженерийн шийдлийг төсөллөх; • Халиа тошин, үер, уруйгаас хамгаалах байгууламжийг төсөллөх; • Мал амьтны зам хөндлөн гарах магадлал бүхий цэгүүдийг судалгаагаар тогтоож, мал, амьтан авто замыг хөндлөн гарах гарцыг төлөвлөх; • Хяналтын цэгүүдийн ерөнхий төлөвлөлтийн зураг төсөл; • Газар хөдлөлтөөс үзүүлэх нөлөөллийг тооцох; • Суурин газрын гэрэлтүүлэг болон цахилгаан хангамж, явган хүний аюулгүй байдлыг хангасан гарц, шаардлагатай бол гэрлэн дохио суурилуулахаар төсөллөх; • Замын трасст орсон өндөр хүчдэл, агаарын шугам, цахилгаан, дулаан, холбооны шугам сүлжээ, шилэн кабелийг зөөх, шилжүүлэх, хамгаалах ажлын нарийвчилсан зураг төсөл, нүүлгэн шилжүүлэх ажлын төсөв гаргаж баталгаажуулах; • Авто замын трасст орсон нүүлгэн шилжүүлэх барилга байгууламжийн зураг төсөл, зардлын тооцоог гаргаж, ИДТ-д тусгах; • Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөлд тусгах; • Замын хөдөлгөөн зохион байгуулалт, тоноглолын зураг төслийг нарийвчлан боловсруулах;

- Зөвлөх нь бүх өгөгдөл, инженерийн нарийвчилсан зураг, баримт бичгийн үнэн зөв, иж бүрдлийг бүрэн хариуцах бөгөөд шаардлагатай бол барилгын ажлын тендер шалгаруулалтын үед зохих тодруулгыг өгнө.
- Зургийн байгууллага хариуцлагын даатгалд хамрагдсан байх;
- Инженерийн нарийвчилсан зураг төслийн иж бүрдлийг захиалагчаар хянуулж, зөвшилцсөний дараа магадлалд хамруулах;

Хянасан:

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.БОЛОР-ЭРДЭНЭ

Авто замын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.СУГАРМАА

Авто замын бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч Д.ЗАГДРАДНАА

Боловсруулсан:

Авто замын бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн Д.ОЮУНБИЛЭГ

БАТЛАВ:
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

А0103 ДУГААРТАЙ САЙНШАНД-ЗАМЫН-ҮҮД ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМД БАЙРЛАХ ЗАМЫН-ҮҮДИЙН ТӨЛБӨР АВАХ ЦЭГИЙГ ШИНЭЧЛЭН БАРИХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2024 оны 08 дугаар сарын 01-ны өдөр Дугаар № 32 Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн А/139 дугаар тушаалын хавсралтын 7 дугаар хэсэгт заасныг үндэслэл болгов.
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	- Сайншанд-Замын-Үүд чиглэлийн авто замд байрлах Замын-Үүд төлбөр авах цэгт. Төлөвлөлтийн талбай: Улсын чанартай авто замын зурвас газарт 4.0 га;
3	Зориулалт, хүчин чадал	- Төлбөр авах цэгийн барилга байгууламжийг Монгол Улсын стандарт "Авто замын төлбөр хураах цэг" MNS 6592:2016 стандартыг баримтлан төсөллөнө. • Төлбөр авах цэгийн зам талбай: Төлбөр авах цэгийн зам талбайг 5 эгнээ бүхий, Замын-Үүд талаас нэвтрэхэд 3 эгнээтэй, Улаанбаатар талаас нэвтрэхэд 2 эгнээтэй байхаар төлөвлөнө. Дотор талын 2 эгнээнд суудлын, зорчигч тээврийн болон жижиг оврын ачааны автомашинаас төлбөр авах, бусад гадна талын 3 эгнээнд том оврын ачаатай тээврийн хэрэгслийн даац хэмжих зориулалттай, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дунд хэмжилт хийх зураасан автопүү (Стандарт хэмжил зүйн газраар баталгаажилт хийлгэсэн байх.) суурилуулна. Мөн зураасан автопүүгээр хэмжилт хийх үед даац хэтэрсэн тээврийн хэрэгслийн бодит жинг хэмжих зориулалтаар төлбөр авах цэгээр нэвтэрч гарах үед нэмэлт эгнээ төлөвлөн статик автопүүг төлбөр авах цэгийн хоёр талд тус бүр 1, нийт 2 ширхэгийг суурилуулахаар тооцож зураг төслийг боловсруулна. Төлбөр авах цэгийн зам талбайн хучилтыг төмөр бетон хийцлэлтэй байхаар төлөвлөнө. • Тээврийн хэрэгслийг түр саатуулах зогсоол: Замын хоёр талд тус бүр нэг нэг байх ба зөрчил гаргасан хүнд даацын, том оврын тээврийн хэрэгслүүдийг түр саатуулах хашаатай байна. Түр саатуулах хашааны хэмжээг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчимтэй уялдуулан тооцож гаргана. Эхний ээлжинд түр саатуулах талбайг хайрган хучилттайгаар төсөллөж болно. • Саравч: Төлбөр авах цэгийн саравчийг олон улсын загвар, дизайн судлан, шинэлэг, орчин үеийн хийц загвартайгаар төсөллөнө. Саравчны өндөр 6 метрээс багагүй, төлбөр авах байр болон ойр орчмын зам талбай, камер, тоног төхөөрөмжийг цас, ус борооноос бүрэн хамгаалах хэмжээний өргөнтэй байна. Мөн ус бороо, салхи шуурганд тэсвэртэй, бат бөх, шинэлэг материалаар (сүүлийн үед ашиглаж байгаа) хийх бөгөөд саравчны каркасын бат бөх байдлыг сайтар тооцон зураг төсөлд тусгаж, зураг төслийг батлуулах шатанд захиалагч болон ашиглагч байгууллагатай зөвшилцөнө. Нарны эх үүсвэрээр сэргээгдэх эрчим хүчний нөөц боломжийг судлан, төлбөр авах байр, ажилчдын байрны дулаан, эрчим хүчийг хангах тооцоо судалгааг хийх. • Төлбөр авах байр 4 ширхэгийг барина. Голын төлбөр авах байранд суудлын, зорчигч тээврийн болон жижиг оврын ачааны автомашинаас төлбөр авах, гадна талын 3 төлбөр авах байранд

		том оврын ачаатай тээврийн хэрэгслээс төлбөр авч, даац хэмжихээр тооцно. Зураг төсөлд суудлын автомашин, жижиг оврын болон том оврын ачааны автомашины жолоочтой шууд харьцаж төлбөр авахад саадгүй байхаар тооцож төлбөр авах цонхны өндрийг төсөллөнө. Цаг агаарын ямар ч нөхцөлд төлбөр авах үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлсэн, дулаан алдагдалгүй, бат бөх, шинэлэг материалаар (сэндвич хавтангаас бусад сүүлийн үед ашиглаж байгаа) хийнэ. Нарны эрчим хүчээр халаалтыг шийдвэрлэх пассив байрыг тооцож үзэх. Мөн төлбөр авах цэгийн байрыг тээврийн хэрэгсэл мөргөж эвдэхээс хамгаалсан хамгаалалт бэхэлгээг зураг төсөлд тооцож оруулна. • Авто зам ашигласны төлбөрийг цахимаар авахад шаардлагатай тээврийн хэрэгслийг дугаар таних камер, тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээ уншигч (RFID), орчны хяналтын камер, овор хэмжээ мэдрэгч, PTZ камер, автомат хаалт болон бусад цахим тоног төхөөрөмжийг суурилуулахаар тооцно. • Төлбөр авах цэгийн ажилчид, автотээврийн улсын байцаагч нарын ажиллах, амрах байрыг стандартын дагуу тоосго болон түүнтэй дүйцэхүйц материалаар дулаан алдагдалгүй, цахилгаанаар халах, дотроо ариун цэврийн бие засах өрөөтэй, бохирын байгууламжийг орчин үеийн технологиор шийдвэрлэсэн байна. Серверийн тусдаа өрөөтэй байх ба орчныг бүтэн харах интерерийн шийдлээр төсөллөнө.
4	Одоогийн байдал	- Суурьшлын бүс бий болсон тохиолдолд төлбөр авах цэгийн барилга байгууламжийн зураг төслийг уг суурьшлын бүстэй давхцуулахгүйгээр боловсруулна.
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан зураг төсөл боловсруулах ажлын гэрээнд заасан хугацаа буюу 2024 оны III улиралд багтаан дуусгаж, захиалагчид хүлээлгэн өгнө.
6	Төслийн захиалагч	- Зам, тээврийн яам
7	Төсөл боловсруулах байгууллага	- Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага зураг төслийг боловсруулна.
8	Төсөл боловсруулах үе шат	- Техникийн төсөл • Загвар зураг /эскиз/; - Ажлын зураг төсөл • Иж бүрэн ажлын зураг төсөл; • Төсөв; Захиалагч байгууллагын саналыг тусган эх загвар зургийг зөвшилцөн ажлын зураг төслийг хийж гүйцэтгэнэ.
9	Архитектур орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	- Орчны архитектур орон зайн төлөвлөлттэй уялдуулан хогийн сав (ангилан ялгах), сандал, саравч, явган хүний зам, талбай гэх мэт архитектурын жижиг хэлбэрүүдийг төлөвлөх.
10	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	- Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны зам талбай, барилга байгууламжтай уялдуулан шийдвэрлэх; - Цахилгаан, холбоо, мэдээллийн кабел утсыг авто зам доогуур тусгай сувагчлал гарган байрлуулна. - Төвлөрсөн цахилгаан хангамжийн системд холбох; - Төвлөрсөн мэдээлэл холбооны сүлжээнд холбох;
11	Төсөлд ашиглах материал	<u>Монгол Улсын хуулиуд:</u> - Авто замын тухай хууль; - Барилгын тухай хууль; - Газрын тухай хууль; <u>Норм, нормативууд:</u> - Авто замын төлбөр хураах цэг. Ерөнхий шаардлага MNS 6592-2016 - Авто зам төсөллөх ЗЗБНбД 22-004-2016 - Авто зам барилгын ажлын төсвийн жишиг норм ЗЗБНбД 83-025-

		2023 - Авто зам барилгын үйлдвэрлэлийн жишиг норм ЗЗБНбД 81-017-2023 - Авто зогсоол БНбД 21-05-10 - Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4596:2014 - Замын тэмдэглэл. Техникийн шаардлага MNS 4795:2014 - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад ашиглагдах норм ба дүрмүүд; Бусад холбогдох норм, дүрэм;
12	Онцгой нөхцөл	- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан тэмдэг тэмдэглэл, тоноглол, гэрэлтүүлгээр бүрэн хангагдсан байх; - Цахилгааны болон ундны усны нөөц эх үүсвэртэй байх; - Интернетийн сүлжээнд бүрэн холбогдсон байх; - Төлбөр авах цэгт тээврийн хэрэгслийн дугаар таньдаг /LPR/ камер, орчны хяналтын камер, тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээ "RFID" уншигч, автомат хаалт, электрон самбар зэрэг цахим тоног төхөөрөмжийг иж бүрдлээр суурилуулах бөгөөд зураг төслийг батлуулах шатанд захиалагч байгууллагаас тодорхой санал авч тусгана.

АВТО ЗАМЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.СУГАРМАА

АВТО ЗАМЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ЗАМЫН АШИГЛАЛТ, ЗАСВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЭРДЭНЭ-ОЧИР

АВТО ЗАМЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.ОЮУНБИЛЭГ